



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/65 дугаар 2018/ЧЧ-СЧ-ПШЗ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Төв номын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад 1,671,179.0 /Нэг сая зургаан зуун далан нэгэн мянга нэг зуун далан есөн/ төгрөгийн зөрчил илэрлээ

1. Дөрөвдүгээр улирлын шатахууны тооцоог бодоогүй, аудитын явцад дөрөвдүгээр улирлын жолоочийн замын хуудсыг ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн өрөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, Төрийн аудитын тухай хуулийн 21.1-т /Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдэш шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй/, Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад /автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм мөрдөх/ заасныг;

2. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн сангаас зарцуулсан.

Энэ нь 16.5.5-т /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал батлах тухай"-д /Ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшууллын зардлууд энэ ангилалд хамаарна. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянана/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын

байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх<sup>1</sup>, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-т /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуузохих ёсоор хөтлөөгүй/, 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулаат бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулжс, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсон/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийг үр ашигтай, эдийн засгийн ангиллыг баримталж, зарцуулахд
2. Анхан шатны баримтын бүрдлийн хангаж, шатахууны тооцоог бодож хэвших;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг аймгийн Төв номын сангийн төсвийн шууд захирагч Ц.Одончимэг, нягтлан бодогч М.Мөнгөншагай нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:



ЗӨВШӨӨРСӨН:



АУДИТОР

Т.ОБОУН-ЭРДЭНЭ ДАРГА

П.ОДОНЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Т.ОБОУН-ЭРДЭНЭ ДАРГА

М.МОНГӨНШАГАЙ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт ханагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлаа, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.